

МОНГОЛ УЛС ДАХЬ АПОСТОЛИК АЙЛЧЛАЛ

*Гэгээн Пап Францисын хандаж хэлсэн үг  
Хамба лам нар, санваартнууд, шашин дэлгэрүүлэгчид,  
сахилтнууд болон шашны хариуцлагатны ажилчидтай  
хийсэн уулзалт*

*Петр, Паул Гэгээнтнүүдийн Катедрал, Улаанбаатар  
2023 оны 9-р сарын 2*

Хайрт ахан дүүс ээ, та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая!

*Томилгооны  
үндэс суурь*

Эрхэмсэг Хамба таны хэлсэн үгэнд баярлалаа, гэлэнмаа Салвиа, санваартан Петр Санжаажав болон Руфина та бүгдийн гэрчлэлд баярлалаа, энд хүрэлцэн ирсэн та бүгдэд, та бүхний сүсэг бишрэлд баярлалаа! Та бүгдтэй уулзаж байгаадаа туйлын баяртай байна. Сахилтны болон санваартны амьдралд энэ биеэ өргөсөн та бүхнийг энэ нутагт ирж бусад эгэл сүсэгтэн ах дүү нарын хамт Эзэнд болон бусдын төлөө өөрсдийгөө зориулахад түлхэц болсон учир шалтгаан бол Сайн мэдээний баяр баясал юм. Үүний төлөө би Тэнгэрбурханд талархаж та бүхэнтэй зарим санаа бодлыг хуваалцахдаа миний суурилж ярих Дуулал 34-н нэгэн сайхан магтаалын залбирлыг хэлье. «Эзэн сайн гэдгийг амсацгаа, үзэцгээ!» (мөр 9)

*Томилгооны  
тодорхойлолт*

“Амтлах ба үзэх”, учир нь Эзэний баяр баясгалан, сайн сайхан байдал нь түр зуурын зүйл биш харин бидний дотор үлдэж, амьдралд амт нэмж, аливааг шинээр харуулдаг билээ. Руфина, үүнийг чи өөрийн гайхалтай гэрчлэлээр бидэнд хэллээ. Тиймээс би юун түрүүн Сайн

мэдээний төлөө явсан нүүр царайнууд, түүхүүд, зориулсан амьдралуудыг санан дурсаж энэ нутаг дахь итгэл бишрэлийн амтыг амтлахыг хүсэж байна. Сайн мэдээний төлөө амьдралаа зориулах гэдэг нь Христийн сүсэгтэн хүний сайн мэдээ дэлгэрүүлэх дуудлага ялангуяа сүсэгтэн хүмүүс уг дуудлагаар энэ газар хэрхэн амьдрах вэ гэдгийг тодорхойлж буй нэгэн сайхан тодорхойлолт юм.

*Хамба лам  
Венсеслао  
Падилла*

Тийнхүү би Монгол дахь Католик шашны орчин цагийн түүхийн суурийг тавигчдын нэг, анхны Апостолик тэргүүн хамба лам агсан, энэхүү Катедралыг босгон байгуулсан эрхэм болох Венсеслао Селга Падиллаг дурсан эхэлмээр байна. Гэхдээ энэ нутагт Христийн итгэл бишрэл зөвхөн өнгөрсөн зууны 90-ээд онд эхлээгүй юм. Энэ нь маш эртний үндэс язгууртай. Эхний мянган жилийн түүхэн хуудаснаа торгоны зам дагуу тархсан Сирийн уламжлалт Сайн мэдээ дэлгэрүүлэлтийн ул мөр тэмдэглэгдэн үлдсэн байдаг ба үүний дараагаар шашны чухал илгээлт эхэлсэн: XIII зууны дипломат илгээлтүүдээс гадна 1310 оны үед Монголын Их Юань гүрний асар уудам бүс нутгийг хариуцуулахаар Ханбалиг хотын анхны хамба ламаар Жиованни да Монтекорвиног томилсон үйл явдлаас харагдах Католик шашны анхаарал халамжийг хэрхэн дурсахгүй байж болох билээ? Тэрхүү хамба лам бол Дуулал ба Шинэ Гэрээг монгол хэлнээ анх хөрвүүлсэн хүн юм. Сайн мэдээний төлөөх цогтой тэмүүллийн энэ агуу түүх ер бусын замаар 1992 онд Мариагийн гэм зэмгүй зүрх сэтгэл хэмээх (The Congregation of the Immaculate Heart of Mary) байгууллагаас өнөөгийн Монгол улсад анхны

*Эртний  
түүх*

*Орчин  
цагийн түүх*

шашин дэлгэрүүлэгч нар хүрэлцэн ирж араас нь бусад институтийн төлөөллүүд, шашны хүрээний санваартнууд, сайн дурын эгэл сүсэгтнүүд нэмэгдэн ирснээр ахин сэргэсэн. Би тэр бүх хүмүүсийн дотроос эрч хүчтэй, хичээнгүй санваартан Стефано Ким Сон Хёныг дурсмаар байна. Мөн яг одоо энд хамт байгаа болон Христийн төлөө амьдралаа зориулсан Монгол дахь Сайн мэдээний үйлчлэгч олон олон сүсэгтнүүдийг дурдмаар байна. Та бүхэн Христийн сайн сайхан та нарын дотор болон та нараар дамжин үйлдэгдсээр байгаа гайхамшгуудыг үзэж, амталж байгаа билээ.

*Томилгооны  
утга учир*

Гэхдээ яагаад өөрийн амьдралыг Сайн мэдээний төлөө зориулна гэж? Энэ бол миний та бүхэнд тавьж буй асуулт юм. Христийн сүсэгтний амьдрал асуултууд тавигдсанаар урагш явдаг. Руфина хэлсний адил *яагаад* гэдэг насан дээрээ хүүхдүүд бүгдийг ойлгохгүй учраас шинэ зүйлсийн талаар байнга асуудаг шиг юм. Христийн сүсэгтний амьдрал биднийг Эзэнд ойртуулж, Эзэнийг илүү сайн таньж мэдэх, сургаалыг нь илүү сайн ойлгохын тулд үргэлж асуулт асууж байдаг. Та бүхэн Есүсээр өөрийгөө харагдахуйц, хүрч болохуйц, учирч болохуйц болгосон Тэнгэрбурханы оршихуйг “амталсан” (Дуулал 34) учраас Сайн мэдээний төлөө амьдралаа зориулдаг. Тийм ээ, Есүс бол бүх ард түмэнд зориулагдсан Сайн мэдээ юм. Тэр бол Католик шашны байнга тунхаглаж, амьдралдаа тусгаж мөн хүмүүсийн болон соёлуудын зүрхэнд “шивнэх” мэдээ билээ. Тэнгэрбурханы хэл яриа ихэвчлэн аажуухан шивнээ байдаг ба цаг хугацаа шаардана. Тэнгэрбурхан ийм замаар ярдаг.

Христийн дотор Тэнгэрбурханы энэрэл хайрыг мэдэрсэн туршлага нь бидний царай төрхийг хувиргаж гэрэлтсэн болгодог цэвэр ариун гэрэл юм. Ахан дүүс минь, Христийн сүсэгтний амьдрал Эзэний царайг бишрэн харах явдлаас төрөн гардаг. Энэ нь энэрэл хайр болон [Тэнгэрбурханы] Үгээр, амийн Талхаар, бусдын нүүр царайгаар, дотор нь Есүсийн оршихуй байдаг ядуу хүмүүсээр дамжин Эзэнтэй хийх өдөр бүрийн уулзалтын тухай юм. Гэлэнмаа Салвиа та үүний талаар гэрчлэлээрээ санууллаа. Баярлалаа! Та энэ газар хориос илүү жил байснаас гадна эдгээр хүмүүстэй хэрхэн ярилцахыг сурч авчээ. Баярлалаа танд.



Хүний цогц  
хөгжилд  
анхаарах  
Шашны  
үүрэг  
амлалт

Монгол дахь энэ гучин нэгэн жилийн хугацаанд эрхэм санваартан, шашин дэлгэрүүлэгч, сахилтнууд болон шашны хариуцлагатны ажилчид та бүхэн эрч хүчээ нэлээдгүй шингээсэн ба сайн самари хүнийг буюу Христийн энэрэл нигүүлслийн нүүр царайг тусган

харуулсан олон төрлийн буяны үйл хэргүүдийг санаачлан эхлүүлжээ. Энэ нь нэг ёсондоо та бүхний нэрийн хуудас бөгөөд нийгмийн халамж тусламж ба боловсролоос эхлээд эрүүл мэндийн үйлчилгээ, соёлыг хөхүүлэн дэмжих зэрэг янз бүрийн салбарт олон хүмүүст үзүүлж буй арвин их ач тусын төлөө та бүхэн бусдын хүндлэл бишрэлийг хүлээсэн. Би та бүхнийг Монголын хайрт ард түмэнд үнэхээр үр өгөөжтэй, ашиг тустай байх энэхүү замаа цааш энэрэл хайрын үйлдэл болон буяны үйлсээрээ үргэлжлүүлээрэй хэмээн уриалж байна.



Үүний зэрэгцээ та бүхнийг Эзэний оршихуйг амтлах ба харах гэдэг зүйлд уриалмаар байна. Өөрөөр хэлбэл бүх зүйл эхэлсэн тэрхүү анхны харц руу (Эзэнийг) байнга шинээр буцан очиж байгаасай хэмээн та бүхнээс хүсье. Эс бөгөөс үнэндээ хүч чадал суларч, сүмийн үйл хэрэг нь

Сайн мэдээ  
дэлгэрүүлэл-  
тийн гол  
төв

хоосон үйлчилгээ, хийх ёстой ажлуудын жагсаалт болон хувирах эрсдэлтэй бөгөөд зөвхөн ядралт, гонсрол төрүүлэх болно. Харин үүний оронд Христтэй хамт байж, Ариун судраас Түүнийг харж, Ариун авдрын<sup>1</sup> өмнө Түүнийг чимээгүй бишрэн бясалгаж, тунгаан эргэцүүлбэл та үйлчилж буй хүмүүсийнхээ царайнаас Түүнийг таньж, дотоод баяр баясгаланг мэдрэх болно. Энэ нь хүнд хэцүү үед ч таны зүрх сэтгэлд амар амгаланг авчирдаг. Олон төсөл хэрэгжүүлсэн завгүй, сатаарсан мөн түүнчлэн заримдаа мэдээж хялбар биш нь ойлгомжтой амьдралд дургүйлхсэн харагдах хүмүүс биш байх нь бидэнд өнөөдөр болон үргэлж хэрэгтэй. Харин шүтэн бишрэх, чимээгүйхэн шүтэн бишрэх чадвартай нэгнийг Христийн сүсэгтэн гэнэ. Тэгээд дараа нь энэхүү шүтэн бишрэхүйгээс үйл ажиллагаа ундарч гарна. Яалаа ч шүтэн бишрэхүйг мартаж болохгүй. Бид энэхүү прагматик зуунд шүтэн бишрэхүйн утгыг бага зэрэг алдсан. Шүтэн бишрэхийг болон шүтэн бишрэхүйгээс аливаа зүйлсийг хийхээ битгий мартаарай. Эх сурвалж буюу Есүсийн нүүр царай руу, амтлах хэрэгтэй Түүний оршихуй руу буцах шаардлагатай. Тэр бол бидний эрдэнэ (Матай 13:44), түүний төлөө бүх зүйлээ зарцуулж болох үнэт сувд (Матай 13:45-46). Ази тивийн нэг онцлог шиг Монголын ахан дүүс бол ариун дагшин зүйлийн талаар өндөр мэдрэмжтэй төдийгүй шашин шүтлэгийн арвин баялаг, тод томруун түүхтэй билээ. Та бүхнээс энэхүү гэрчлэлийг хүсэн хүлээж байна, мөн та бүхэн жинхэнэ мөн чанарыг таньж чаддаг. Энэ бол та бүхний өгөх гэрчлэл юм. Учир нь Сайн

---

<sup>1</sup> Христийн бие талх хэлбэрээр хадгалагдах сүмд байрлах ариун хайрцаг.

мэдээ албадлага шахалтаар өсөн дэлгэрдэггүй.  
Сайн мэдээ гэрчлэлээр өсөн дэлгэрдэг билээ.



*Шүтэн бишрэхүй*

*Үнэн ба ядуу  
даржин  
байдал*

Эзэн Есүс шавь нараараа улс төрийн үзэл санааг түгээлгэхийн тулд бус харин тэднийг түүний Эцэгтэй буюу одоо биднийх болсон Эцэгтэй (Иохан 20:17) тогтоосон харилцааны талаарх шинэ зүйлийг амьдралаараа гэрчил хэмээн дэлхийд илгээсэн. Энэ шинэ зүйл хүн бүртэй, ард түмэн бүртэй ахан дүүгийн бодит барилдлагатай байх эх үүсвэр болдог. Энэхүү илгээлтээс мэндэлсэн Шашин бол зөвхөн жинхэнэ итгэл бишрэл ба Амилсан нэгний зэвсэггүй, зэвсэггүй болгогч хүчинд суурилсан мөн шархалсан хүн төрөлхтний зовлон зүдүүрийг хөнгөвчилж чадах ядуу даржин Шашин юм. Тийм ч учраас засгийн газрууд болон шашнаас ангид байгууллагууд Шашны Сайн мэдээг түгээх үйлдлээс айх зүйлгүй, учир нь Шашинд улс төрийн зорилго байхгүй, харин бүх нийтийн сайн сайхныг дэмжих чадалтай Тэнгэрбурханы хишиг ивээл, үнэн болон энэрэл нигүүлслийн Үгийн даруу хүчийг л зөвхөн хүлээн зөвшөөрдөг.

*Шашны мөн  
чанар*

Уг томилолтыг биелүүлэхийн тулд Христ хүний биеийн ялгаатай эрхтнүүдийн зохилдлогоог сануулдаг бүтцээр Шашнаа бэлтгэсэн. Христ бол Тэргүүн өөрөөр хэлбэл, Шашныг удирдан чиглүүлсээр байх толгой юм. Түүнчлэн Бие буюу бидний дотор өөрийн Сүнсийг цутгадаг. Энэхүү Сүнс нь ялангуяа шинэ амьдралын тэмдэг болсон шашны үндсэн ёслолуудын дотор ажиллаж байдаг. Шашныхаа үнэн зөв, үр нөлөөтэй байлдыг батлан даахын тулд Христ Эзэн санваартны хэргэмийг тогтоосон бөгөөд энэхүү хэргэм нь хонин сүргийнхээ төлөө амиа өгдөг Христ сайн Хоньчинтой нэгдэх дотно харилцааг харуулсан байдаг билээ. Петр санваартан чи ч бас энэхүү томилолтыг биелүүлэхээр дуудагдсан: чи өөрийн туршлагаасаа бидэнтэй хуваалцсанд баярлалаа! Ингэснээр мөн Монгол дахь Тэнгэрбурханы ариун ард түмэн Ариун Сүнсний билигт хишгүүдээр дүүрэн байна. Энэ өнцгөөс харвал, Хамба ламыг зүгээр нэг менежер биш харин ард түмнээ цуглуулж удирддаг Христ сайн Хоньчны амьд дүр зураг гэж харахыг би та бүхэндээ уриалж байна: Учир нь Хамба лам бол Христ доторх та бүхний ахан дүүсийн ёсыг тогтоож, үүнийгээ язгуурлаг эрхэм өв соёлтой энэ үндэстэнд улам бүр суулгах томилолттой Эзэний элчийн сүнслэг мөн чанараар бүрэн дүүрсэн нэгэн шавь мөн. Тэгэхээр та бүхний Хамба лам Кардинал цолтой болсон үйл явдал нь ойр дотно байдлыг томруун илэрхийлдэг юм: та бүгд зөвхөн бие махбодын хувьд хол байгаа хэдий ч Петр гэгээнтний зүрх сэтгэлд нэн ойрхон байдаг шүү. Үнэндээ Католик шашин та нартай, мөн танай жинхэнэ католик буюу бүх нийтийн түгээмэл нэгдэлтэй ойрхон

*Хамба  
ламын  
танигдахуй  
ба үүрэг  
оролцоо*

байдаг бөгөөд та бүхэн Католик шашны энэ их эв нэгдлээр дамжуулан дэлхий даяар тархан суурьшсан бүх ахан дүүсийн сайхан сэтгэлийг Монгол руу хандуулж байна.

*Нэгдэл*

*Нэгдэл:* би энэ үгийг онцольё. Шашныг цэвэр функциональ шалгуурын үндсэн дээр ойлгож болохгүй. Хэрэв функциональ шалгуураар харвал Хамба лам нь олон янзын бүрэлдэхүүн хэсгүүдийг магадгүй олонхын зарчимд тулгуурладаг зохицуулагчийн ажил хийдэг хүн болно. Харин Шашныг сүнслэг зарчмын үндсэн дээр ойлгох хэрэгтэй бөгөөд Хамба лам гэдэг хүний оршихуйгаар Есүс Христ өөрөө сүнслэг Биеийнхээ буюу Шашныхаа дотор нэгдлийн баталгаа өгдөг. Өөрөөр хэлбэл Шашин доторх нэгдмэл байдал гэж эмх журам, ёслол хүндлэлийн асуудал биш. Тэр тусмаа “багаар ажиллах” сайн стратеги ч биш. Энэ бол Эзэнд итгэх итгэл, энэрэл хайрын асуудал бөгөөд Түүнд үнэнч байх тухай юм. Тиймээс шашны бүх бүрэлдэхүүн хэсгүүд нь амьд Христийг түүний Ард түмний дунд төлөөлж буй хамба ламынхаа эргэн тойронд бат нягт холбоотой байж бид өөрсдийнхөө номлодог болон итгэл бишрэлийг соёлд амьдруулахад тусалдаг тэрхүү синодын (хамт алхах) төлөөх нэгдлийг барьж босгодог байх нь чухал юм.

*Эгэл жирийн байдал ба соёлд нийцүүлэх үйл явц*

Эрхэм шашин дэлгэрүүлэгч нар аа, та бүхнийг яг энд Монголд өөрийн хайрыг гэрчлүүлэхээр дуудсан Христэд өөрсдийгөө бүрэн зориулахын гоо сайхныг хийгээд өөрсдөө бэлэг гэдгээ амталцгаа, үзэцгээ. Нэгдлийн үрийг тарьж энэ замналаа үргэлжлүүлцгээ. Үүнийгээ илжигний нуруун дээр сууж Иерусалимд орж

ирсэн, эцэст нь загалмай дээр хувцсаа тайлуулсан Эзэнийг дуурайж, эгэл амьдралын энгийн даруу байдлаар хэрэгжүүл. Тэнгэрбурханы зам бол хүмүүстэй ойрхон байх юм. Тийм л байдлаар хүмүүстэй та бүхэн үргэлж ойрхон бай. Тэнгэрбурхан бол ойр ханддаг, өрөвч энэрэнгүй ба уян зөөлөн. Ойр байдал, өрөвч энэрэнгүй ба уян зөөлөн байдал: хүмүүст ийнхүү ханд, тэдэнд биечлэн анхаарал тавьж, тэдний хэлийг сурч, соёлыг нь хүндэтгэн хайрла. Дэлхийн тав тухад бүү татагдацгаа, харин сүнслэг болон ёс суртахууны амьдралын үлгэр жишээ, зөвт байдлаар дамжуулан Сайн мэдээнд тууштай байцгаа. Эгэл даруу ба хүмүүстэй ойрхон байдал!



Учирсан нүүр царайнууд, хүмүүсийн түүхүүд, асуудал бэрхшээл ба сэтгэл зовнилуудыг Есүст хүргэхээс бүү алжаа. Өдөр бүрийн залбиралд цагаа зориул. Уг залбирал та бүхнийг үйлчлэлийн ажилдаа хүнд хэцүүтэй учирлаа ч хөл дээрээ зогсох мөн "Бүх тайтгарлын Тэнгэрбурхан"-аас (2 Кор 1:3) зовлон амсаж буй хүмүүсийн зүрхэнд

цутгах хэрэгтэй горьдол найдварыг татан авах боломжийг олгоно.

*Шударга  
ёсны  
төлөөх  
үүрэг  
амлалт*

Ахан дүүс ээ, Эзэнтэй ойрхон байцгаахад үнэндээ бидний дотор нэгэн үл эргэлзээ хүчтэй болдог бөгөөд үүнийг Дуулал 34 бидэнд цаг ямагт илчилдэг: «Эзэнээс эмээгчдэд юу ч дутагддаггүй [...] Эзэнийг хайгчид ямар ч сайн зүйлээр гачигдахгүй» (10-11). Мэдээж амьдралын алдаа дутагдал, хүндрэл бэрхшээлүүд итгэгчдэд ч гэсэн нөлөөлдөг ба сайн мэдээ дэлгэрүүлэгчид хүмүүний л амьдралын нэг хэсэг болох санаа зовнилын ачаанаас чөлөөлөгдсөн хүмүүс биш юм. Дууллыг дуулагч хорон муу санаатай хүмүүс болон муу явдлын тухай ярихаас айдаггүй, харин даруу хүмүүсийн хашхирах дууны өмнө «Эзэн түүнийг тэр бүх зовлон зүдүүрээс нь чөлөөлдөг», учир нь «Эзэн эмтэрсэн зүрхнүүдэд ойрхон байх агаад» мөн «Сүнсээрээ гэмшигчдийг авардаг» (18-19) – гэдгийг дуулдаг. Ийм учраас Католик шашин дэлхий даяарх ядуу, тарчиг бүх хүмүүстэй нэгдэн тэдний дуу хоолой нь болж, шударга бус явдлын өмнө дуугүй өнгөрдөггүй бөгөөд хүн бүрийн эрхэм чанарыг дэмжих үйлсэд даруухнаар өөрийгөө зориулдаг билээ.

*Мариагийн  
оршихуй*

Хайрт ахан дүүс ээ, энэхүү шашин дэлгэрүүлэгч шавь байх аян зам дээр та нарт нэгэн найдвартай дэмжлэг бий. Энэ бол Манай тэнгэрлэг Эх. Тэрээр өөрийн зөөлөн халамжтай оршихуйн бодит тэмдгийг та бүхэнд өгөхийг хүссэн ба хогийн цэгт өөрийнх нь дүр бүхий энэхүү баримлыг үлдээсэн. Үүний талаар олж мэдэхдээ би туйлын баяртай байсан! Цэвэр Ариун Мариагийн энэ үзэсгэлэнт баримал хаягдсан зүйлсийн газраас гарч ирсэн: Толбогүй,

гэм нүглээс хамгаалагдсан тэрээр нийгмийн хог хаягдалтай андуурагдах хэмжээнд өөрийгөө доош буулган тэгтлээ бидэнтэй ойрхон ирэхийг хүссэн. Тийнхүү бидний тэнгэрлэг эх Тэнгэрбурханы Ариун Эхийн цэвэр ариун байдал овоолсон хог хаягдлаас үзэгдэн гарч ирсэн. Би сүүн далай шиг агуу зүрхтэй ээж буюу сүүн далай эжий хэмээх нэгэн сонирхолтой монгол уламжлалын талаар мэдэж авлаа. Монголын нууц товчоо-нд гэрийн тооноор орж ирсэн гэрэл домогт Алун гоо хатны хэвлийд үлддэг тухай гардаг. Та нар бас Цэвэр Охин Мариа эхээр дамжуулан өдөр бүр дээрээс Монгол дахь Католик шашны алхам бүрийг дагах тэнгэрлэг гэгээн гэрлийн үйлсийг тунгаан бодож болно.

*Сайн  
мэдээний  
дагуух  
өчүүхэн  
байдал*

Мариа Эх рүү харцаа өргөхдөө өчүүхэн жижиг байх нь асуудал биш, харин аливаа бүхний ундарга гэдгийг ойлгож, тайвширцгаа. Тийм ээ, Тэнгэрбурхан өчүүхэн бяцханыг хайрладаг бөгөөд өчүүхэн жижгээр дамжуулан агуу үйлсийг үйлдэхийг хүсэн таалдаг. Үүнийг Мариа гэрчилж байна (харьц. Лук 1:48-49). Хайрт ахан дүүс ээ, та бүхэн цөөхөн тооноос, хараахан ирээгүй амжилтаас, үр дүнгүй байдлаас бүү айцгаа. Энэ нь Тэнгэрбурханы зам мөр биш. Мариаг харцгаа, түүний өчүүхэн байдал нь тэнгэрээс уудам юм. Учир нь, тэрээр тэнгэр, тэнгэрүүдийн тэнгэр ч багтааж чадамгүй Нэгнийг өөртөө тээж байсан (харьц. 1 Хаад 8:27). Сайн мэдээг баяр баясгалантайгаар гэрчлэхээс ядардаггүй шатаж буй хайр, эрч хүчээр дүүрэн хичээл зүтгэлийг гуйн түүнд өөрсдийгөө даатгацгаая. Урагшаа алхацгаа: Тэнгэрбурхан та нарт хайртай. Тэр таныг сонгосон ба танд итгэж байгаа. Би та

бүгдтэй хамт, чин сэтгэлээсээ та бүхэнд хандаж хэлэхэд: баярлалаа. Та бүхний гэрчлэлд баярлалаа. Сайн мэдээг түгээж, амьдралаа зориулж буйд тань баярлалаа. Залбирахдаа тууштай, буяны үйлсийг үйлдэхдээ бүтээлч бүтээмжтэй, эв нэгдлээр явахдаа тэсвэр тэвчээртэй, юм бүхэнд ба хүн бүхэнд хандахдаа баяр дүүрэн ба зөөлөн сэтгэлтэйгээр үргэлжлүүлж явцгаа. Би та бүгдийг адисалж, санаж байх болно. Мөн миний төлөө залбирахаа бүү мартаарай.

Гялайлаа та бүхэндээ!

Францис

## Хувийн болон нийтийн эргэцүүлэлд зориулсан асуултууд

1. Пап Францисын үгс миний сэтгэлийн гүнд ямар мэдрэмж, дурсамжыг сэргээж байна вэ?
2. Папын биднээс хүсч байгаа зүйлийг би/бид яаж биелүүлэх вэ?

